



**Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог  
ДЭМЖИХ ТӨСӨЛ**

Мэдээллийн эмхэтгэл №5 (2017 он 12-р сар)

**“Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх” Япон дахь сургалтын тусгай дугаар**

**Япон дахь сургалтын эхний өдөр**

2017.12.12



12 дугаар сарын 11-ний өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх сургалт”-д оролцох 8 хүн Япон улсыг зорилоо. Тэмүүлэн /тархины саажилттай/, түүний туслах ажилтан Мөнхболд нар Япон улсад анх удаа очих гэж буй учраас хурдхан нисэхийг тэсэн ядан хүлээж байсан юм. Наритад буусны дараа хилийн шалган нэвтрүүлэх хэсэгт хурууны хээ уншуулах шаардлагатай байсан нь хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд бага зэрэг хүндрэлтэй байлаа. Онгоцны буудлаас гараад сургалтын байрруугаа явсан бөгөөд тусгай зориулалтын өргөгч лифттэй автобусаар зорчсон. Сургалтанд оролцогчид замын турш Токио хотыг цонхоор харан “зам нь ямар гоё юм бэ”, “түгжрэлгүй юм байна” гэх зэргээр ярилцаж байлаа. Сургалт 12-ны өдрөөс эхэлсэн бөгөөд сургалтын хугацаанд олон зүйлийг сурч мэднэ гэдэгт итгэлтэй байна.

**Япон дахь сургалт 1 “ХБИ-ийн ажил эрхлэлтийн тухай”**

2017.12.16



12 дугаар сарын 12-ны өдөр буюу сургалтын эхний өдөр Японы ХБИ-ийн Сэргээн засалтын холбооны Тэрашима багш “Хөдөлмөр эрхлэлт”-ийн сэдвээр лекц орлоо. Сургалтаас бусад орнуудтай харьцуулахад Япон улсад ХБИ-ийн ажлын байрны квот сайн хэрэгждэг тухай, мөн ХБИ-ийн квотыг ханган ажиллаагүй байгууллагаас сар бүр торгуулийн мөнгө хураан авч түүнийг ХБИ-ийг ажиллуулж буй байгууллагуудыг дэмжих, ажил хөдөлмөрийн дадлага олгоход ашиглан ХБИ-ийн ажил эрхлэх бүтцийг бий болгож буй талаар мэдээлэл авлаа. Сургалтанд оролцогчид “Япон улсад Хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг хэрхэн тогтоодог вэ?” гэдгийг сонирхон асууж байсан юм. Монголд “Хөдөлмөрийн чадвар”-аар нь тодорхойдог бол Японд тийм биш. Япон улсад “бие эрхтний үйл ажиллагааны бэрхшээл” буюу нүд нь ямар түвшинд хардаг, хөлөө хэр зэрэг хөдөлгөж чадаж байна зэргээр нь сэтгэц, бие эрхтний бэрхшээлийн түвшинг нарийвчлан тодорхойлдог. Өөрөөр хэлбэл Японд бол “Сэтгэц, бие эрхтний бэрхшээл”, “Ажил хийж чадах эсэх” хоёр тусдаа ойлголт юм. “Хөдөлмөрийн чадварыг хэн тогтоодог юм бол оо? Бие эрхтний бэрхшээл гэдэг нь Хөдөлмөрийн чадвар алдагдалтай гэсэн ойлголт зөв эсэх гэх мэтээр Оролцогчид өөрийн орны нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож сургалтад идэвхтэй хамрагдлаа.

**Япон дахь сургалт 2 “Хүртээмжтэй орчин хүмүүсийн ойлголт хандлагаас...”**

2017.12.17



12 дугаар сарын 13-ны өдрийн үдээс өмнө Японы DPI холбооны Иманиши багшийн лекц орлоо. Тэрээр олон жил ХБИ-ийн “зорчих эрх”-ийн чиглэлээр ажиллаж ирсэн. Үдээс хойш нь сургалтад оролцогчид багшийн хамт метро, автобусны хүртээмжтэй байдалтай танилцав. Эхлээд метроны Хатагая буудлаас Акэбонобаши буудал хүртэл явж, тэндээсээ автобусаар Шинжюү галт тэрэгний буудлын баруун хаалга хүртэл явлаа. Мөн явган хүний замын авто замтай огтлолцсон хэсгийн налуу, замын гарцанд суурилуулсан хөтөч замтай танилцлаа. Сургалтанд оролцогчид “Ажилчид метронд суух, буух үед зөөврийн налуу зам тавьж өгөхөөс гадна цахилгаан шат хүртэл замчилж өгч байсан”, “Ийм үйлчилгээ нь метроны буудлын ажилчид, автобусны жолооч нарын өдөр тутмын ажил үүргийнх нь нэг хэсэг юм байна” гэх зэргээр сэтгэгдлээ илэрхийлж байв. Ялангуяа

үйлчилгээгээ улам сайжруулахын тулд ажилчид сар бүр тогтмол сургалтад хамрагддаг болох нь сайхан сэтгэгдэл төрүүлэв. “Хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд тусгай өндөр технологи ашиглаагүй. Харин нийтийн тээврийн салбарт ажиллаж буй албан хаагчдын зөв хандлага ухамсар, нэн чухал гэдэг ойлголтыг улам бататгаж чадлаа.



### Япон дахь сургалт 3 "Тэргэнцэртэй продюссер"

2017.12.18

12 дугаар сарын 14-ний үдээс өмнө ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар NHK телевизийн продюссер Такэучи яриа хийлээ. Тэрээр 3 настайдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд их сургуульд орох хүртэлх замнал, анх ажилд хэрхэн орж байсан, одоо ямар ажил хийж байгаа гээд өөрийн амьдралын олон сайхан түүхийг ярьж өгсөн юм. Мөн 30 гаруй орноор ганцаараа аялсан, Америкт сонинь сурвалжлагчаар ажиллаж байхад ямар байсан гэх мэт яг л киноны зураглал мэт байсан ба сургалтад оролцогчид түүний ярианаас урам зориг авсан гэдэгт итгэлтэй байна. Дараа нь оролцогчид "Анх ажилд орох үед ямар нэг ялгаварлан гадуурхалт байсан уу?", "Таныг сурвалжлага авахаар очиход тэргэнцэртэй гэдгийг тань хараад ямар байдлаар ханддаг байсан бэ?", "Ажил үүргийн хувьд бусад ажилчдаас ялгаатай зүйл байдаг уу?" гэх мэтээр олон асуулт асууж, харилцан ярилцлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй байх эсэхээс үл хамааран хүн бүр ажил мэргэжилдээ хариуцлагатай хандах нь нэн чухал хэмээн өгүүлэх Такэучи продюссерын ярианаас олон зүйлийг ойлгож авлаа.

### Япон дахь сургалт 4 "ХБИ гэдэг нь?"

2017.12.19

12 дугаар сарын 14-ний үдээс хойш Шинжюкү дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн хэлтсийн сургалтад хамрагдан Японд хөгжлийн бэрхшээлийг хэрхэн тодорхойлдог, мөн "ХБИ"-д ямар ямар үйлчилгээ үзүүлж байгаа талаар мэдээлэл авлаа. Тус сургалтад хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох явц, түвшингийн ангилал, халамжийн дэвтэр, туслах үйлчилгээ, улсаас олгож буй туслах хэрэгсэл гэх мэт Япон улсын ХБИ-ийн халамжийн үйлчилгээний талаарх ерөнхий ойлголтыг олж авч чадлаа. Сургалтад оролцогчид "Орон нутгаасаа шалтгаалан ХБИ-д үзүүлж буй үйлчилгээ өөр байдаг уу", "Асрамжийн газрыг хаанаас танилцуулдаг вэ?" "ХБИ-ийн тэтгэмж, тэтгэврийг өөр хэн нэгэн хүн хэрэглэхээс сэргийлсэн хуулийн заалт байдаг уу?" гэх мэт асуулт асууж тавьж харилцан ярилцав. Оролцогчдын олонх нь хөгжлийн бэрхшээлтэй, халамжийн үйлчилгээнд хамрагддаг хүмүүс учраас өөрийн орны нөхцөл байдалтай харьцуулангаа багшийн яриаг идэвхтэй сонсож байлаа.

### Япон дахь сургалт 5 "Япон улсын Сэргээн засалтын үндэсний төв"

2017.12.24



12 дугаар сарын 15-ны өдөр ХБИ-ийн Сэргээн засалтын үндэсний төвтэй танилцсан бөгөөд угтах хэсэгт Монгол улсын төрийн далбааг тавьсан байгааг хараад сургалтанд оролцогчид их баяртай байлаа. Тус төв нь эмчилгээ, сэргээн засалт, бие даан амьдрах дасгал сургуулилт гэх мэт цогц үйлчилгээг үзүүлдэг. Сургалтанд оролцогчид тус төвийг ямар том бүтэцтэй юм бэ гэж өөр хоорондоо ярилцацгааж байсан ба "Гадаад хүн ч гэсэн үйлчлүүлэх боломжтой юу?" гэх мэтээр сонирхон асууж байв. Барилга байгууламж, тоног төхөөрөмж, орчин нөхцөл маш сайн байсан бөгөөд ахуй заслын сургуулилтыг гарын доорх, өртөг багатай зүйл ашиглан хийж буй жишээ ч байлаа. Тус төвийн

дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийн сэргээн засалтын төв нь тоног төхөөрөмж, зураг төсөл, компьютерийн программ, оффисийн ажилтан бэлтгэх курс гээд олон чиглэлээр сургалт явуулдаг. "38 жилийн өмнө анх үүсгэн байгуулагдах үед бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр голлон сургалт явуулж байсан бол одоо хамгийн эрэлттэй байгаа нь оффисын ажилтан бэлтгэх анги болсон байна. Цаг үеийнхээ эрэлт хэрэгцээг дагаад дадлага сургуулилт олгох курсууд ч гэсэн өөрчлөгдөж байна." хэмээн сургалт хариуцсан хэлтсийн дарга өгүүлж байлаа. Тус төв нь зөвхөн ХБИ-ийг төдийгүй, ХБИ-ийг ажилд авах сонирхолтой бизнесийн байгууллагуудыг ч гэсэн дэмжин ажиллаж байна. Хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн явуулж буй үйлчилгээнүүдийн талаар сургалтанд оролцогчид чих тавин сонсож байсан юм.



### Тусгай олимпийн хороотой хамтран DAISY ярьдаг номыг танилцууллаа

2017.12.19



Тусгай олимпийн хорооноос Нийслэлийн 63-р сургуулийн сурагч, эцэг эхчүүдэд зориулсан сургалт зохион байгууллаа. Тус сургалтын үеэр DET-н сурагч багш Заяа ярьдаг цахим номыг танилцуулсан бөгөөд хүүхдүүд дэлгэцэнд гарч буй номыг ихэд сонирхон харж байлаа. Тус сургалтад биеийн тамирын заал дүүрэн хүн хамрагдсан. Заяа ч гэсэн 63-р сургуулийг төгссөн бөгөөд сурагч, эцэг эхчүүдэд өөрийгөө танилцуулахын зэрэгцээ тус номыг хэрхэн хэрэглэх талаар сайтар заалаа. Багш нарын хэлж байгаагаар сурагчдад хамгийн ихээр тулгамдаж буй асуудал бол сургуулиа төгссөний дараа ажилд орж чадахгүй байх явдал гэж байсан юм. Сургуулиа төгссөний дараа ч гэсэн олон зүйлд идэвхтэй суралцаж буй Заяаг хараад эцэг эхчүүд урам зориг авсан байх аа.

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

**Цахим хуудас:** <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

**И-мэйл:** [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)



**Фэйсбүүк хуудас:** <https://www.facebook.com/jicadpub>